



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/161

Номгон

Сургуулийн менежментийг сайжруулах  
хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслахад  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргааны 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сургуулийн менежментийг сайжруулах хяналт шинжилгээ хийх, зөвлөн туслахад дэмжлэг үзүүлэх ажлын удирдамж, төсвийг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг) -т үүрэг болгосугай.

3.Арга хэмжээний зардал болох 5.174,400 (Таван сая нэг зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун төгрөг)-ийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний “Чадварлаг багш” арга хэмжээ зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642310393

16  
Аймгийн Засаг даргын 23 дугаар  
сарын 28 ны өдрийн 9/16 дүгээр  
захирамжийн захирамжийн хавсралт



**СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ЯВЦ  
АХИЦЫГ ТАНДАХ, ЗӨВЛӨН ТУСЛАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

**Зорилго.** Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний VI систем ашиглан суурь гарааны түвшинд анализ хийн асуудлыг тодорхойлж төлөвлөлт, менежмент хийсэн үйл ажиллагаатай танилцах, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

**Зорилт:**

Гүйцэтгэлийн үнэлгээний мөрөөр зохион байгуулсан үйл ажиллагааны ахиц өөрчлөлт, одоогийн бодит нөхцөл байдал.

Сургуулийн менежмент, удирдлагын манлайллын сайн санаа, туршилтыг цуглуулах.

**Хугацаа.** 2023 оны 03 дугаар сарын 27-31-ний өдөр

**Хамрах хүрээ:** Баянхонгор сумын "Номгон" ахлах сургууль, 5 дугаар ЕБС, Баян-овоо, Галуут, Мандлын бага сургууль, Жаргалант, Заг, Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагч, багш нар.

**Үйл ажиллагааны агуулга, чиглэл**

1. Байгууллагын үнэлгээний 6 үзүүлэлт (үр дүнг ахиулах, үйл ажиллагааг оновчтой болгох талаар баримталж буй сургуулийн менежмент, загвар, арга аргачлал.

Чиглэл 1	Үйл ажиллагаа 2	Ажлын хэсэг 3
1. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дата мэдээлэлд хийсэн шинжилгээ. дүн	1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт ба сурлагын ахиц, амжилт; 2. Суралцагчийн хөгжил хамгаалал ба сургуулийн олон талт үйл ажиллагаа сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоо; 3. Багш, ажилтны тасралтгүй хөгжил ба багшийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт; 4. Сургалтын орчин бүрдүүлэлт ба анги танхим,	Г. Батбаяр
	лаборатори, цахим танхимын нөхцөл байдал; 5. Удирдлагын манлайлал ба харилцаа хандлага, ёс зүй, багш нарын ажилд тусалж дэмжиж буй ажил, үр нөлөө, хяналт, хариуцлага, манлайлал; 6.	

1	2	3
	<i>Хэрэглэгчийн сэтгэл ханамж ба нөлөөллийн үйл ажиллагааны цар хүрээ, түүвэр судалгаа сэтгэл ханамж, оролцоо;</i>	
2. VI систем ба дата бааз.	<i>Судлагдахууны үнэлгээний мэдээлэлд тулгуурлан суурь судалгаа хийсэн байдал. авч хэрэгжүүлж буй арга аргачлал.</i>	М.Мөнхбат О.Будхүү Г.Одонтунгалаг Б.Нямдолгор
3. Багш нарын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлж буй мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажил, сургалтын хөтөлбөр.	<ul style="list-style-type: none"> <li>- СӨБ-ын сургалтын хөтөлбөр</li> <li>- Бага боловсролын сургалтын хөтөлбөр</li> <li>- Байгалийн ухааны сургалтын хөтөлбөр</li> <li>- Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр</li> <li>-Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр</li> </ul>	М.Мөнхбат О.Будхүү Г.Одонтунгалаг Б.Нямдолгор
4. Сургуулийн онцлогт тохирсон менежмент	Сургуулийн онцлогтой арга аргачлал, менежментийг засан сайжруулах ажиглалт тэмдэглэл хийсэн байдал.	Г.Батбаяр

#### ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

Чиглэл	Үйл ажиллагаа	Үнэлгээ
1.Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дата мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ.	<i>R1-Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт R2-Суралцагчийн хөгжил хамгаалал R3-Багш, ажилтны тасралтгүй хөгжил R4- Сургалтын орчин бүрдүүлэлт R5-Удирдлагын манлайлал R6-Хэрэглэгчийн сэтгэл ханамж</i>	$\frac{(R1+R2+R3+R4+R5+R6)*100}{6}$ <i>/0-100/</i>
2. VI систем ба дата бааз.	<i>Судлагдахууны үнэлгээний мэдээлэлд тулгуурлан суурь судалгаа хийсэн байдал. авч хэрэгжүүлж буй арга аргачлал.</i>	0-100
3. Багш нарын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлж буй мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажил, сургалтын хөтөлбөр.	<ul style="list-style-type: none"> <li>- СӨБ-ын сургалтын хөтөлбөр</li> <li>- a. Бага боловсролын сургалтын хөтөлбөр</li> <li>- b.Байгалийн ухааны сургалтын хөтөлбөр</li> <li>- c-Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр</li> <li>-d-Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр</li> </ul>	$\frac{(a+b+c+d)*100}{4}$ <i>/0-100/</i>
4. Сургуулийн онцлогт тохирсон менежмент	Сургуулийн онцлогтой арга аргачлал, менежментийг засан сайжруулах ажиглалт тэмдэглэл хийсэн байдал.	0-100
Дундаж оноо		

### Үнэлэх аргачлал

1. “Үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

2. Тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);

3. Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь);

4. Зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, 0 хувь (0-30 хүртэл хувь);

### СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ЯВЦ АХИЦЫГ ТАНДАХ, ЗӨВЛӨН ТУСЛАХ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	“Сайн хичээл” ажил арга хэмжээг зохион байгуулан түгээн дэлгэрүүлж, гом гарын авлага гаргах	72	55000	3.960.000
2	Тээвэр шатахуун	2400	2530	1214400
	Бүгд			5.174,400

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_